

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны  
жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/002/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089116 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88012671 Цахим хаяг: [ichinkhorlooga@audit.gov.mn](mailto:ichinkhorlooga@audit.gov.mn)

Аудитор : Б.Ариунтуяа

Утас: 99036832 Цахим хаяг: [ariuntuyab@audit.gov.mn](mailto:ariuntuyab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025. 02. 25 № 1/166  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР  
ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Т.РАДНААБУД

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

2024 онд 2013 оноос хойш санхүүгийн дэмжлэг авсан 844 иргэнээс нийт 1,459,202.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг төвлөрүүлэн ажилласан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, хөтлөлтэй холбоотой 1 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.

#### Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газрын даргатай 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 13 зорилт, 60 арга хэмжээтэйгээр байгуулж, хэрэгжилтийг 88.4 хувьтай үнэлэгдсэн байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6725021552

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,077,470,346.00</u></b>	<b><u>4,064,611,868.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	4,077,470,346.00	4,064,611,868.00
<b>33700</b>	Хөтөлбөртэй холбоотой авлага	3,808,674,000.00	4,058,671,868.00
<b>33703</b>	Хувираа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	2,067,355,200.00	1,927,293,662.00
<b>33705</b>	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	257,624,503.00	238,071,453.00
<b>33706</b>	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	993,997,267.00	1,220,608,067.00
<b>33717</b>	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	184,918,030.00	458,204,300.00
<b>33718</b>	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	206,069,000.00	143,992,605.00
<b>33720</b>	Аймаг, нийслэл дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл	90,710,000.00	64,351,781.00
<b>33730</b>	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	8,000,000.00	6,150,000.00
<b>33300</b>	Татаас санхүүжилтийн авлага	268,796,346.00	
<b>33500</b>	Бусад авлага		5,940,000.00
<b>33510</b>	Байгууллагаас авах авлага		5,940,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,077,470,346.00</u></b>	<b><u>4,064,611,868.00</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>108,000.00</u></b>	<b><u>108,000.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	108,000.00	108,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	108,000.00	108,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	108,000.00	108,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	108,000.00	108,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>4,077,362,346.00</u></b>	<b><u>4,064,503,868.00</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,077,362,346.00	4,064,503,868.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	4,077,362,346.00	4,064,503,868.00
51210	Өмнөх үеийн үр дүн	3,293,795,290.00	4,072,562,346.00
51220	Тайлант үеийн үр дүн	783,567,056.00	(8,058,478.00)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>4,077,470,346.00</u></b>	<b><u>4,064,611,868.00</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,409,551,000.00</b>	<b>2,743,524,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,409,551,000.00</b>	<b>2,743,524,600.00</b>
<b>120</b>	<b>Өмчийн орлого</b>	2,409,551,000.00	2,743,524,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,409,551,000.00	2,743,524,600.00

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,396,362,200.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,500,000.00	33,660,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	985,688,800.00	1,650,869,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,625,983,944.00</b>	<b>2,751,583,078.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,625,983,944.00</b>	<b>2,751,583,078.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	106,057,054.00	149,162,443.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	106,057,054.00	149,162,443.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	106,057,054.00	149,162,443.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,519,926,890.00	2,602,420,635.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	601,442,600.00	610,772,740.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	601,442,600.00	610,772,740.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	9,240,000.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,240,000.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	5,000,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,000,000.00	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	904,244,290.00	1,991,647,895.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	904,244,290.00	1,991,647,895.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>783,567,056.00</b>	<b>(8,058,478.00)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>783,567,056.00</b>	<b>(8,058,478.00)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,409,551,000.00</b>	<b>2,737,584,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,409,551,000.00</b>	<b>2,737,584,600.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,409,551,000.00	2,737,584,600.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	2,409,551,000.00	2,737,584,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,396,362,200.00	1,058,995,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,500,000.00	<b>27,720,000.00</b>
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	985,688,800.00	1,650,869,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,335,672,290.00</b>	<b>4,196,786,732.00</b>

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,335,672,290.00</b>	<b>4,196,786,732.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>107,300,254.00</b>	<b>149,162,443.00</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	107,300,254.00	149,162,443.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	107,300,254.00	149,162,443.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,228,372,036.00</b>	<b>4,047,624,289.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,041,091,400.00	2,324,772,740.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,041,091,400.00	2,324,772,740.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	9,240,000.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,240,000.00	-
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	5,000,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,000,000.00	-
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,173,040,636.00	1,722,851,549.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,173,040,636.00	1,722,851,549.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>(926,121,290.00)</u></b>	<b><u>(1,459,202,132.00)</u></b>
14	<b>Бусад эх үүсвэр</b>	926,121,290.00	1,459,202,132.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	926,121,290.00	1,459,202,132.00
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>926,121,290.00</u></b>	<b><u>1,459,202,132.00</u></b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	926,121,290.00	1,459,202,132.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	4,077,362,346.00	4,077,362,346.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	4,077,362,346.00	4,077,362,346.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	4,077,362,346.00	4,077,362,346.00
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	4,077,362,346.00	4,077,362,346.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-4,800,000.00	-4,800,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	4,072,562,346.00	4,072,562,346.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-8,058,478.00	-8,058,478.00

D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	4,064,503,868.00	4,064,503,868.00
-----	---------------------------------------	------	------	------------------	------------------

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/Төгрөгөөр/**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,709,864,600.00	2,473,935,183.00	235,929,417.00	91.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,709,864,600.00	2,473,935,183.00	235,929,417.00	91.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	149,162,443.00	149,162,443.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	149,162,443.00	149,162,443.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	149,162,443.00	149,162,443.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,560,702,157.00	2,324,772,740.00	235,929,417.00	90.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,560,702,157.00	2,324,772,740.00	235,929,417.00	90.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,560,702,157.00	2,324,772,740.00	235,929,417.00	90.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,945,794,017.00	2,709,864,600.00	235,929,417.00	91.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,945,794,017.00	2,709,864,600.00	235,929,417.00	91.9
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,294,924,417.00	1,058,995,000.00	235,929,417.00	81.7
350002	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,650,869,600.00	1,650,869,600.00	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00		100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00		100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	60.00	60.00		100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	47.00	47.00		100.0
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00		100.0

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Бүртгэл, хөтлөлттэй холбоотой 1 зөвлөмжийг Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дарга, нягтлан бодогч нарт хүргүүлэн ажилласан.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлээгүй байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулагдаж буй бараа материалын орлого, зарлагыг бөөн дүнгээр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “үнэн зөв байх” 6.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө, УСНББОУС 12-ын параграф 16 "Бараа материалыг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд тэдгээрийн өртгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнээр хэмжинэ" гэж заасантай болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Зөвлөмж:** Сургалтын болон, дэмжих үйл ажиллагааны зардлын бараа материалын орлого, зарлагын гүйлгээг анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх, Бараа материалын нэршил тодорхой, тоо хэмжээ, хэмжих нэгжийг үнэн зөвөөр бүртгэлд тусгах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын бүртгэл	1	48,913.0					1	48,913.0		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>48,913.0</b>					<b>1</b>	<b>48,913.0</b>		